

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АВТО ЗАМЫН САНГИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТ 62.5 ХУВЬТАЙ, ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД:

АРА-2022/16-1-ШТА-ГА



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn  
Багийн ахлагч, Ахлах аудитор Х.Алтанчимэг  
Утас: 9006-0105 Цахим хаяг: altanchimegkh@audit.gov.mn  
Аудитор Г.Цог-Эрдэнэ  
Утас: 9921-0906 Цахим хаяг: Tsog-erdeneg@audit.gov.mn  
Аудитор Ж.Мөнгөншагай  
Утас: 9090-9190 Цахим хаяг: Mungunshagaij@audit.gov.mn

ЦЭЦЭРЛЭГ ХОТ  
2022 ОН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



Тайлан бэлтгэсэн:

Архангай аймаг дахь  
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор:  
Т.Байгалмаа

Аудитын менежер:  
Д.Нэргүйбаатар

Ахлах аудитор:  
Х.Алтанчимэг

Аудитор:  
Ж.Мөнгөншагай

2022 оны 04 дүгээр  
сар

Уг тайланг УАГ-ын Веб  
сайт-аас үзнэ үү.

[www.audit.mn](http://www.audit.mn)

*Аудитын тайлан,  
дүгнэлттэй  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах,  
асууж лавлах зүйл  
байвал 70332860  
дугаарын утас,  
70333141 дугаарын  
факсаар харилцана уу*

ХАЯГ:

Эрдэнэбулган сум  
Аймгийн ЗДТГ-ын  
байр 3-р давхар 311  
тоот

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	3-4
<b>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА.</b>	<b>8</b>
1. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх, зохистой арга хэмжээг аваагүй байна.	8
2. Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтийг хангуулаагүй байна.	
<b>БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.</b>	<b>8-10</b>
1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	10
2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн байна.	11
3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн үр дүн хангалтгүй байна.	11-13
4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн 33.3 хувийг хэрэгжүүлээгүй байна.	13-15
<b>ДҮГНЭЛТ</b>	
<b>ЗӨВЛӨМЖ</b>	<b>15-18</b>
<b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ</b>	
<b>ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ</b>	
График 1 Хөрөнгө оруулалт БББ-тэй уялдан байдал	19
График 2. Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт	
График 3. Худалдан авах ажиллагааны журам сонголт	20
График 4. ОНӨГ-ын сүүлийн 3 жилийн ХАА-ны журмын сонголт	
График 5. ТАХ-г гэрээний хугацаанд гүйцэтгэсэн байдал	21
График 6: Захиалагч, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдал	
График 7: ТАХ-ний гүйцэтгэлийн байдал	22-23
График 8: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	
Хүснэгт 1. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г хууль, журмын заалттай уялдуулан төлөвлөсөн байдал	
Хүснэгт 2: Ажлын даалгаваргүй ТАХ-ний жагсаалт	
Хүснэгт 3.Хуулийн дагуу зайлшгүй хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалт	
Хүснэгт 4. Мэргэжлийн байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын жагсаалт	
Хүснэгт 5. Санхүүжилтийн гүйцэтгэл олгосон байдал	

## ***Товчилсон үгийн жагсаалт***

<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
<b>АРА</b>	Архангай аймаг
<b>БББ</b>	Бодлогын бичиг баримт
<b>ГА</b>	Гүйцэтгэлийн аудит
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ИТХТ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
<b>СС</b>	Сангийн Сайд
<b>СТСХ</b>	Санхүү, төрийн сангийн хэлтэс
<b>СХАА</b>	Санхүүгийн хяналт, аудитын алба
<b>ТАХ</b>	Төсөл, арга хэмжээ
<b>ТБОНӨХБАҮХАТХ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ХАА</b>	Худалдан авах ажиллагаа
<b>ХОХБТХ</b>	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
<b>ШТА</b>	Шууд тайлагнах аудит



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

<b>Аудитын нэр:</b>	Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг
<b>Аудитын код:</b>	АРА-2022/16-1-ШТА-ГА
<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</b>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын жилийн төлөвлөгөө”-ний дагуу хийлээ.</p>
<b>Аудитын зорилт:</b>	<p>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, орон нутгийн удирдлагын шийдвэр гаргах түвшинд туслах, аудитаас үр дүнтэй зөвлөмж хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>• Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үр нөлөөтэй эсэх</li><li>• Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх</li></ul>
<b>Аудитын хүрээ:</b>	<p>хамрах</p> <p>Аудитаар аймгийн орон нутгийн 2021 оны төсвийн хөрөнгө оруулалт буюу авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 8 ТАХ-ний төлөвлөлт хийсэн судалгаа, ТЭЗҮ, зураг төсөл, ажлын даалгавар, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн хийлээ.</p>
<b>Аудитын арга зүй:</b>	<p>Аудитад Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, баримт бичгийг судлах зэргээр асуудлын шинжилгээний тохирох аргазүйг ашиглав. Аудитын явцад цуглуулсан баримт материалыг шинжлэхдээ нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, нотлох баримтыг бүлэглэх, нэгтгэн дүгнэх зэргээр Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөөний аргазүйг ашиглан аудитын хөтөлбөр</p>



горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлсийг ажлын баримт материалд хавсаргав.

**Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:**

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Авто замын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 9 тогтоол */Архангай аймгийн тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026 дунд хугацааны бодлогын баримт бичиг/*
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 09 тогтоол */аймгийн 2021 оны төсөв батлах тухай/*
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 09 тогтоол */аймгийн 2021 оны тодотгосон төсөв батлах тухай/*
- МУЗГ-ын 2019 оны 312 дугаар тогтоол */Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам/*
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол */Босго үнэ батлах тухай/*
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал */Журам шинэчлэн батлах тухай/*

**Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн Аудитын хугацаа:**

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Х.Алтанчимэг, аудитор Ж.Мөнгөншагай нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ. Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс эхлүүлж, 4 дүгээр сарын 30 -ны өдөр дуусгахаар төлөвлөж аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулан саналыг авч, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

**Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:**

Аудитын тайлан оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, аудитын зөвлөмж, хавсралт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Аудитын тайланд аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах бүх нотлох зүйл, мэдээллийг хангалттай зохистой хэмжээгээр оруулсан болно.



## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Архангай аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04 ний өдрийн 09 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жасгаалтыг батлаагүй бөгөөд авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 842.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бүхий 6 ТАХ-нд тайланд онд 315.0 сая төгрөг зарцуулахаар жагсаалтыг баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн “2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 09 дүгээр тогтоолоор авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтанд 2 ТАХ-г нэмж тусгаснаар авто зам засвар, арчлалттай холбоотой 905.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2021 онд 377.6 сая төгрөгөөр санхүүжих 8 ТАХ-г баталсан байна. Гүйцэтгэлээр тайланд онд бүрэн хэрэгжиж ашиглалтанд хүлээн авсан 5 ТАХ-ний гүйцэтгэгч нарт 123.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, дараа онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан ТАХ-ний санхүүжилт 50.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлжээ. Харин тайланд онд огт хэрэгжээгүй 2 ТАХ-ний санхүүжилт болох 200.0 сая, захиалагчийн хяналтын зардал 3.8 сая, нийт 203.8 сая төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлжээ.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “... Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хөрөнгө оруулалтын арга хэмжээнд санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна ...” гэж заасан боловч 2021 оны авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, төсвийн зарцуулалтын байдалд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.

---oO---



**БҮЛЭГ 1.****АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮР  
НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА.****А.1. АЙМГИЙН АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ҮР АШИГТАЙ  
ТӨЛӨВЛӨХ, ЗОХИСТОЙ АРГА ХЭМЖЭЭГ АВААГҮЙ БАЙНА.**

**А.1.1 Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ нь үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байна.**

График 1.

Тайлант онд аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 8 ТАХ нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр<sup>1</sup> болон “аймгийн эдийн засаг нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”<sup>2</sup>-тэй уялдсан байна.



**А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь хууль, журмын заалтын хүрээнд зарцуулахаар төлөвлөсөн тул төсвийн шууд захирагчаас санал авах шаардлагагүй байна.**

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 8 ТАХ-нь Авто замын тухай хуулийн 24.3<sup>3</sup>, 24.4<sup>4</sup>, 24.5<sup>5</sup>, МУЗГ-ын 2019 оны 312 дугаар тогтоолоор батлагдсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх захиран зарцуулах журам”-ын 3.3<sup>6</sup>, 3.5.1<sup>7</sup> дэх заалтын хүрээнд зарцуулахаар төлөвлөсөн байгаа нь төсвийн шууд захирагчдаас санал авах шаардлагагүй байна.

<sup>1</sup> Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан

<sup>2</sup> Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан

<sup>3</sup> “...орон нутгийн замын сангийн хөрөнгөөр орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ ...”

<sup>4</sup> “Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ”

<sup>5</sup> “Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ”

<sup>6</sup> “Гэнэтийн хүчин зүйл буюу байгалийн гамшигт үзэгдэл, осол болсны улмаас авто зам, замын байгууламжид эвдрэл, гэмтэл үүссэний улмаас авто замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх боломжгүй болсон тохиолдолд сэргээн засварлахад шаардагдах зардлыг авто замын сангийн тухайн жилийн төсвөөс тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ”

<sup>7</sup> “төсвийн 90-ээс багагүй хувийг Авто замын тухай хуулийн 24.3, 24.4-т тус тус заасан үйл ажиллагаанд зарцуулна”



Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г хууль, журмын заалттай уялдуулан төлөвлөсөн байдал

Хүснэгт 1.

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мянган төгрөг/	2021 онд санхүүжих дүн /мянган төгрөг/	Авто замын тухай хуулийн холбогдох заалт	МУЗГ-ын 2019 оны 312-р тогтоол
1	Арслан цохио чиглэлийн чулуун хучилттай авто замын засвар арчлалт /2020-2022 /	577,453.5	100,000.0	24.4	3.3
2	Нэгдсэн эмнэлгийн авто зам, зогсоолын засвар	150,000.0	100,000.0	24.3	3.5.1
3	Батцэнгэл сумын төвийн замыг сайжруулах	50,000.0	50,000.0	24.3	3.5.1
4	Эрдэнэбулган сумын 1-р баг Халзангийн давааны гүүр, авто замын засвар	20,000.0	20,000.0	24.4	3.3
5	Эрдэнэ булган сумын 1-р багийн эвдэрсэн гуу, жалга, замыг засах	15,567.9	15,567.9	24.4	3.3
6	Эрдэнэбулган сумын 3 дугаар багийн 11 дүгээр цэцэрлэг хүртэлх авто замын засвар	20,000.0	20,000.0	24.4	3.3
7	Цэцэрлэг хотын төв доторх хайрган, хатуу хучилттай авто замын засвар, арчлалт	60,000.0	60,000.0	24.4	3.3
8	Булган хангай хороолол, 7-р багийг холбосон хайрган хучилттай авто замын засвар арчлалт	12,000.0	12,000.0	24.4	3.3
Нийт дүн		905,021.4	377,567.9		

Дээрх хүснэгтээс харахад МУЗГ-ын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх захиран зарцуулах журам”-ын 3.5.1-д “авто замын сангийн төсвийн 90-ээс багагүй хувийг Авто замын тухай хуулийн 24.3, 24.4-т заасан үйл ажиллагаанд хуваарилах” гэж заасны дагуу 2021 оны аймгийн авто замын сангаас 377.6 сая төгрөгийн 8 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

### **А.1.3. ТАХ-ны ач холбогдол эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэн төлөвлөөгүй байна.**

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөж батлахдаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2<sup>8</sup>, 6.5.5<sup>9</sup> -д заасныг хэрэгжүүлээгүй, олон нийтэд нээлттэй мэдээлж оролцоог хангасан, эрэмбэ, дараалал тогтоох, шийдвэрлэх зэрэгт олон нийтийн саналыг харгалзан үзснийг нотлох баримтгүй байна.

### **А.2. АЙМГИЙН АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАХ-ИЙГ ҮР АШИГТАЙ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

А.2.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнийг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангуулсныг нотлох баримтгүй байна.

<sup>8</sup> Төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах

<sup>9</sup> Хөтөлбөр, төсөл арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх





Аймгийн авто замын сангаас 2021 онд шинээр хэрэгжүүлэх 7 арга хэмжээнээс 2 нь зураг төсөв, 5 арга хэмжээнд ажлын даалгавар боловсруулсан байна.

Зураг, төсөв, ажлын даалгавар боловсруулсан байдал

Хүснэгт 2.

№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /мянган төгрөг/	ТЭЗҮ, зураг, төсөв, ажлын даалгаврын аль нь болох	Боловсруулж баталсан байгууллагын нэр, огноо
1	Авто замын сан	Арслан цохио чиглэлийн чулуун хучилттай авто замын засвар арчлалт /2020-2022 /	577,453.5	Зураг төсөв	Тарбаченбүүлэн ХХК, 2018
2		Нэгдсэн эмнэлгийн авто зам, зогсоолын засвар	150,000.0	Зураг төсөв	Танил санаа ХХК, 2021
3		Батцэнгэл сумын төвийн замыг сайжруулах	50,000.0	Ажлын даалгавар	Батцэнгэл сумын Засаг дарга 2021.09.20
4		Цэцэрлэг хотын төв доторх хайрган, хатуу хучилттай авто замын засвар, арчлалт	60,000.0	Ажлын даалгавар	ХОХБТХ, 2021.09.02
5		Эрдэнэбулган сумын 1-р баг Халзангийн давааны гүүр, авто замын засвар	20,000.0	Ажлын даалгавар	ХОХБТХ, 2021.09.02
6		Эрдэнэ булган сумын 1-р багийн эвдэрсэн гуу, жалга, замыг засах	15,567.9	Ажлын даалгавар	ХОХБТХ, 2021.09.02
7		Цэцэрлэг хотын төв доторх хайрган, хатуу хучилттай авто замын засвар, арчлалт	20,000.0	Ажлын даалгавар	ХОХБТХ, 2021.09.02
8		Булган хангай хороолол, 7-р багийг холбосон хайрган хучилттай авто замын засвар арчлалт	12,000.0	Ажлын даалгавар	ХОХБТХ, 2021.09.02
Нийт дүн			905,021.4		

**A.2.2. Төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулаагүй байна.**

Тайлант онд хэрэгжүүлэх 8 ТАХ-нээс 7 ТАХ-г бүрэн дуусгаж ашиглалтанд оруулахаар төлөвлөжээ. Өмнөх оноос шилжиж ирсэн 577.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100.0 сая төгрөгөөр санхүүжих “Арслан цохио чиглэлийн чулуун хучилттай авто зам” нь 2022 онд үргэлжүүлэн хэрэгжүүлэхээр тооцож санхүүжилтийг хуваарилсан нь материалын зардал жил бүр нэмэгдэж байгаа өнөө үед батлагдсан төсөвт өртөгт багтаан хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэсэн байна. Үүний улмаас гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх гэрээг цуцлах хүсэлт гаргаж шийдвэрлэсэн байна. Мөн “Нэгдсэн эмнэлгийн авто зам, зогсоолын засвар”-ын ажил нь төсөвт өртөг хүрэлцэхгүй шалтгаанаар гүйцэтгэгч гэрээ байгуулахаас татгалзжээ. Үүнээс үзэхэд авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ач холбогдол эрэмбэ дарааллыг оновчтой тогтоогоогүй, төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй, санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож батлаагүй байна.

**A.2.3. Хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байна.**

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн дараах арга хэмжээнүүд нь хөрөнгө оруулалтын шинж чанартай бус боловч Авто замын тухай хууль, “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх захиран зарцуулах



журам<sup>10</sup>-д заасны дагуу тэргүүн ээлжинд зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 3.

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мянган төгрөг/	2021 онд санхүүжих дүн /мянган төгрөг/	Авто замын тухай хуулийн холбогдох заалт	МУЗГ-ын 2019 оны 312-р тогтоол
1	Батцэнгэл сумын төвийн замыг сайжруулах	50,000.0	50,000.0	24.3	3.5.1
2	Эрдэнэбулган сумын 1-р баг Халзангийн давааны гүүр, авто замын засвар	20,000.0	20,000.0	24.4	3.3
3	Эрдэнэ булган сумын 1-р багийн эвдэрсэн гуу, жалга, замыг засах	15,567.9	15,567.9	24.4	3.3
4	Эрдэнэбулган сумын 3 дугаар багийн 11 дүгээр цэцэрлэг хүртэлх авто замын засвар	20,000.0	20,000.0	24.4	3.3
5	Цэцэрлэг хотын төв доторх хайрган, хатуу хучилттай авто замын засвар, арчлалт	60,000.0	60,000.0	24.4	3.3
6	Булган хангай хороолол, 7-р багийг холбосон хайрган хучилттай авто замын засвар арчлалт	12,000.0	12,000.0	24.4	3.3

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г батлахдаа олон нийтийн оролцоог хангаж, ач холбогдол, эрэмбэ, дарааллыг тогтооход тэдний саналыг харгалзан үзэх, хэрэгжих боломжтой байдлаар санхүүжилтийг тооцож батлуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

## БҮЛЭГ 2

### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

**Б.1. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.**

**Б.1.1. Төсөл арга хэмжээг хэрэгжих боломжит хугацаанд эрх шилжүүлсэн байна.**

Аймгийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 22-ний А/353 захирамжаар авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Батцэнгэл сумын төвийн замыг сайжруулах” ТАХ-ний эрхийг сумын Засаг даргад шилжүүлсэн байна.

**Б.1.2. Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим ТАХ-ний худалдан авах ажиллагааг тайланд онд бүрэн хэрэгжих боломжит байдлаар зохион байгуулаагүй байна.**

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2021 онд шинээр хэрэгжүүлэх 7 ТАХ-нээс хууль, журамд заасны дагуу 3 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион


<sup>10</sup> Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан.

байгуулахаас аймгийн ОНӨГ-аас 2, эрх шилжүүлсний дагуу 1 ТАХ-ний худалдан авах ажиллагааг Батцэнгэл сумын ЗДТГ тус тус зохион байгуулжээ.

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1, харьцуулалтын аргаар 2 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд хуулийн дагуу 4 ТАХ-ний гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг графикаар харуулбал:

График 2.



Графикаас харахад нийт төсөл, арга хэмжээний 57.1 хувь нь шууд гэрээ байгуулах, 28.6 хувь нь харьцуулалтын аргаар, 14.3 хувь нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Худалдан авалтыг тайлант оны сүүлийн хагаст зохион байгуулсан бөгөөд 1 ТАХ гэрээ байгуулагдаагүй, 1 ТАХ гэрээ байгуулсан боловч хэрэгжээгүй байна.


Тайланд онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны үр дүнгийн талаар:

1. Батцэнгэл суманд эрх шилжүүлсэн “Батцэнгэл сумын төвийн замыг сайжруулах” ажлын худалдан авах ажиллагааг 10 дугаар сард 2 удаа зохион байгуулж 11 дүгээр сард гэрээ байгуулсан нь тайлант хугацаанд хэрэгжих боломжгүй болж дараа онд шилжсэн байна.
2. “Нэгдсэн эмнэлгийн авто зам зогсоолын засвар”-ын ажлын худалдан авах ажиллагааг 2 удаа зохион байгуулахад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул тендерийг хүчингүй болгосон бөгөөд хуулийн дагуу гэрээ шууд байгуулах хэлцэл хийсэн боловч төсөвт өртөг нь хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар оролцогч гэрээ байгуулахаас татгалзжээ.
3. “Цэцэрлэг хотын төв доторх хайрган, хатуу хучилттай авто замын засвар, арчлалт”-ын ажлын худалдан авах ажиллагааг 9 дүгээр сард зохион байгуулж гүйцэтгэгчийг амжилттай сонгон шалгаруулж гэрээт хугацаат ажлыг гүйцэтгүүлсэн байна.

### Б.1.3. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна.

Тайлант онд шинээр хэрэгжүүлэх нийт 7 ТАХ-ээс нээлттэй тендер 1, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 2 ТАХ-ний тендерийн баримт бичгийг Сангийн Сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар баталсан жишиг баримт бичгийн дагуу боловсруулж, үнэлгээний хорооны анхны хуралдаанаар хэлэлцэн, урилга нийтэлсэн өдөр батлуулсан байна. Тендерийн урилгыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайт болон өдөр тутмын Монголын үнэн зэрэг сонинд нийтлүүлж ил тод мэдээлсэн ба Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын дагуу 100 хувь цахимаар зохион байгуулж оролцогчдыг нээлттэй өрсөлдөх боломжоор хангажээ.

График 3.



Тухайлбал: “Нэгдсэн эмнэлгийн авто зам зогсоолын засвар”-ын ажлын нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулахад эхний удаад 1 ч тендер ирээгүй, 2 дахь удаад 1 тендер ирүүлсэн боловч шаардлагад нийцээгүй байна. Иймд хуульд заасны дагуу гэрээ шууд байгуулах хэлцэл хийсэн боловч амжилтгүй болсон байна. Харин аймгийн ОНӨГ-аас “Цэцэрлэг хотын төв доторх хайрган, хатуу хучилттай авто замын засвар, арчлалт”-ын ажлын, Батцэнгэл сумын ЗДТГ-аас “Батцэнгэл сумын төвийн замыг


сайжруулах” ажлын худалдан авах ажиллагааг тус тус харьцуулалтын аргаар цахимаар зохион байгуулж, тендерийн баримт бичиг болон хууль, журмын шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

#### Б.1.4. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж хугацаанд нь тайлагнасан байна.

Архангай аймгийн ТЭЗ-ийн худалдан авах ажиллагааны 2021 оны тайланг ОНӨГ-аас Сангийн яамны хууль эрхзүйн газарт цахимаар хүргүүлжээ. Энэ нь Сангийн Сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.1.5-д заасантай нийцэж байна.

Архангай аймгийн ОНӨГ нь 2021 онд улс, орон нутгийн төсвийн болон байгууллагын захиалгаар нийт 79 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Үүнээс 7 нь аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ ба нээлттэй 1, харьцуулалтын 2, 4 ТАХ-ний шууд гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

График 4.




Аймгийн ОНӨГ-ын сүүлийн 3 жилд зохион байгуулсан авто замын сангийн хөрөнгө оруулалтын ТАХ-ны ХАА-ны журмын сонголтоос харахад нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан ХАА өмнөх 2019, 2020 оноос буурсан, харин харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтын тоо 2020 онд 2019 оноос өсч 2021 онд буурсан байна. Энэ нь хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төсөвтэй ТАХ-ний төсөвт өртөг болон хэмжээ буурсантай холбоотой байна.

#### Б.2. ЗАХИАЛАГЧ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХУГАЦААНД НЬ ХАНГУУЛЖ ҮЕ ШАТНЫ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

##### Б.2.1. Гүйцэтгэгч байгууллага ТАХ-г гэрээний хугацаанд гүйцэтгэсэн байна.

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх 8 ТАХ-ний 7 ТАХ нь тайланд онд бүрэн хэрэгжих ёстойгоос 5 ТАХ-г гэрээт хугацаанд гүйцэтгэсэн бол 1 нь гэрээ байгуулагдаагүйгээс хэрэгжээгүй, 1 нь ХАА оройтсны улмаас дараа онд шилжин хэрэгжих болсон, өмнөх оноос шилжин хэрэгжих ТАХ-ний гэрээ цуцлагдснаас хэрэгжээгүй байна.

График 5.



Тайланд онд бүрэн хэрэгжсэн 5 ТАХ-ний ашиглалт, чанар байдлын талаар ашиглагч байгууллагуудаас гомдол саналыг гаргаагүй байна.

### Б.2.2. Авто зам, барилга байгууламжийн их засварын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 8 ТАХ-ээс нь тайлант жилд 5 нь бүрэн хэрэгжсэн байна.

Захиалагч, зохиогчийн хяналтыг графикаар харуулбал:

График 6



Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нийт 5 ТАХ нь ажлын даалгавартай тул захиалагч байгууллагыг төлөөлж аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

### Б.2.3. Авто зам, барилга байгууламжийн их засварын ажилд захиалагчийн үе шатны хяналтыг хугацаанд нь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд бүрэн хэрэгжсэн 5 ТАХ-ний гүйцэтгэлийн явцад захиалагчийн үе шатны хяналтыг хугацаанд хэрэгжүүлж ил далд ажлын актаар баталгаажуулсан байна.

### Б.2.4. Авто зам, барилга байгууламжийн их засварын ажилд мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан байна.

Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд бүрэн хэрэгжүүлсэн 5 ТАХ нь авто замын урсгал засвар, гуу жалганы эвдрэл зэрэг бага төвөгшилтэй ажил тул явцын дунд мэргэжлийн байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй, харин ажлыг ашиглалтанд хүлээн авахад аймгийн МХГ-ын улсын байцаагч хяналт тавьж үүрэг даалгавар өгснийг тухай бүр хэрэгжүүлсэн байна. Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4.

№	ТАХ-ний нэр	МХГ-ын байцаагчаас өгсөн үүрэг даалгавар
1	Эрдэнэбулган сумын 1-р баг Халзангийн давааны гүүр, авто замын засвар	Далангийн материалыг усалж нягтруулах
2	Эрдэнэ булган сумын 1-р багийн эвдэрсэн гуу, жалга, замыг засах	Далангийн материалыг усалж нягтруулах
5	Булган хангай хороолол, 7-р багийг холбосон хайрган хучилттай авто замын засвар арчлалт	Далангийн хажуу налууг засварлах, хөвөөг нягтруулах

### Б.3. АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

#### Б.3.1. Санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн бүрэн олгосон байна.

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан нийт 8 ТАХ-нд тайлант онд **377.6** сая төгрөгийг зарцуулахаас бүрэн хэрэгжсэн 5 ТАХ-ний гүйцэтгэгч нарт **123.8** сая төгрөгийн санхүүжилтийг олгож, гэрээ байгуулсан боловч дараа онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн ТАХ-ний 50.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна. Харин огт хэрэгжээгүй 2 ТАХ-ний нийт 200.0 сая, аймгийн ЗДТГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн тул хяналтын зардлын 3.8 сая төгрөг нийт 203.8 сая төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлжээ.

Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. /сая.төг/

Хэрэгжүүлэхээр баталсан		Үүнээс:									
		Гүйцэтгэгчид олгосон		Зураг төсөв, зохиогчийн хяналтын зардалд		Захиалагчийн хяналтын зардалд		Барьцаа хөрөнгийн дансанд		Орон нутгийн төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлсэн	
ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн
8	377.6	5	123.8	-	-	-	-	1	50.0	2	203.8


Гүйцэтгэгч нарт олгосон санхүүжилтийн зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган шалгахад зөрчил илрээгүй.

#### Б.3.2. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ТАХ-ний 62.5 хувь нь хэрэгжсэн ч бүртгэлд тусгаагүй байна.

Тайлант онд 8 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 5 ТАХ бүрэн хэрэгжсэн, 1 ТАХ он дамжсан, 2 ТАХ огт хэрэгжээгүй төлөвлөгөөний хэрэгжилт 62.5 хувьтай байна.



График 7.



Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр 2021 онд бүрэн хэрэгжүүлж ашиглалтанд оруулсан 5 ТАХ нь авто замын урсгал засвар, эвдэрсэн гуу

жалга, замын засвар байх тул ашиглагч байгууллага тодорхойгүй, хөрөнгийн бүртгэлд тусгах боломжгүй байна.

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр Эрдэнэбулган сумын доторх авто зам, гуу жалганы эвдрэлийг жил бүр засварлаж байгаа нь сангийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулсан гэж үзэхэд хүргэж байна. Сангийн хөрөнгийг жил бүр үерийн улмаас эвдэрсэн гуу жалга, замыг засах биш дахин эвдрэл үүсэхгүй байхаар үерээс хамгаалах далан, хоолой барих гэх мэт арга хэмжээг төлөвлөж зарцуулах нь зүйтэй байна гэж үзлээ.

Авто замын сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

#### Б.4. Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн 33.3 хувийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх аудит буюу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар **397.1 сая төгрөгийн** зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх таслан зогсооход чиглэсэн 2 албан шаардлагыг холбогдох байгууллагуудад, хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилт, үр дүн, үр ашгийг сайжруулахад чиглэсэн 3 зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох албан тушаалтнуудад тус тус хүргүүлсэн. Санхүүжилтийг 1.1 сая төгрөгөөр илүү тооцож гүйцэтгэгчид олгосныг төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоосон байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн дээрх шийдвэр тус бүрийн хэрэгжилтийг үнэлэхэд төлбөрийн акт, албан шаардлага 100 хувь, зөвлөмж 66.7 хувийн хэрэгжилттэй байна. Зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг графикаар дүрслэн, дэлгэрэнгүй мэдээллийг орууллаа.

#### Албан шаардлагын хэрэгжилт:

- Өмнөх аудитаар авто зам засварын 9 ТАХ-ний гүйцэтгэгчээс авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлтийг аваагүй, захиалагчаас авто зам, замын байгууламжийн ажил эхлүүлэх зөвшөөрлийг гэрээнд заасан хугацаанд олгоогүй ЗТХС-ын 2018 оны 49 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжүүлэх, ашиглалтанд авах журам"-ын 2.1<sup>11</sup>, 2.3<sup>12</sup> дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг бүрэн

<sup>11</sup> "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан хуулийн этгээд нь авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлт гаргахдаа энэхүү журмын 4 дүгээр хавсралтын А хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлж, тухайн авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник технологийн хяналт тавих эрх бүхий Зөвлөх /цаашид Зөвлөх гэх/-өөр хянуулан Захиалагчид хүргүүлнэ"

<sup>12</sup> "...Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг тухайн авто зам, замын байгууламж баригдаж дуусах хүртэлх гэрээнд заасан хугацаагаар олгоно..."

хэрэгжүүлж 2021 онд хэрэгжүүлсэн 5 ТАХ-нд ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна.

- Ажлын даалгаваргүй ТАХ-г төлөвлөж батлуулсан, захиалагч, зохиогчийн нэгдсэн дүгнэлт гараагүй ТАХ-г ашиглалтанд хүлээн авсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хэрэгжүүлж тайланд онд зөрчлийг давтан гаргаагүй.

График 8.

**Зөвлөмжийн хэрэгжилт:**



- Өмнөх аудитаар аймгийн Засаг даргад хүргүүлсэн “авто замын сангийн хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөхдөө ТЭЗҮ, ажлын даалгавар боловсруулсан төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж аймгийн ИТХ-аар батлуулж байх” зөвлөмжийг хэрэгжүүлж 2021 оны жагсаалтанд ТЭЗҮ, зураг төсөв батлагдаагүй төсөл арга хэмжээг тусгаагүй байна.

- “Авто замын сангийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, түүний үр дүн, үр ашгийг тооцож ажиллах” зөвлөмжийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн байна.

Харин Төсвийн тухай хуулийн 69.1 дэх заалтын хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитаас өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж авто замын хөрөнгийн зарцуулалтанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

-----oOo-----



## АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. АЙМГИЙН АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА.
2. АВТО ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 62.5 ХУВЬ, ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой үр ашигтай төлөвлөх, төлөвлөлтөнд олон нийтийн оролцоог хангаж саналыг тусгах, хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнг үнэлж хэвших шаардлагатай байна.

Аудитаас өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах 1 албан шаардлага, авто замын сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоог сайжруулах, үр дүнг тооцож байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

-----oOo-----



## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

### Аймгийн Засаг дарга М.Батжаргалд

1. Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г батлахдаа олон нийтийн оролцоог хангаж, ач холбогдол, эрэмбэ, дарааллыг тогтооход тэдний саналыг харгалзан үзэх арга хэмжээг зохион байгуулах
2. ТАХ-г богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой байдлаар санхүүжилтийг тооцож батлуулах арга хэмжээ авах
3. Авто замын сангийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр ашиг, үр дүнг тооцож үнэлснийг тайлагнаж байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 9 дүгээр сарын 25-ны дотор холбогдох нотлох баримтын хамт Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

-----oOo-----



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛС  
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2 дугаар баг,  
Утас/Факс: (976) 7033 3208,  
И-мэйл: arkhangai.gov@gmail.com,  
Вэбсайт: www.arkhangai.gov.mn

2022.04.29 № 01/357

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

*Аман суурь,  
Х. Агаашия*

*Балжинзор*


*Орш*

*С. Тэм*

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг, Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын тайлангийн төслүүдтэй танилцлаа.

Дээрх тайлангуудтай холбоотой ямар нэгэн санал байхгүй болно.



М.БАТЖАРГАЛ

65139-0000

Тайлан баталгаажуулсан тушаал



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/08

Цэцэрлэг

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9 дэх заалт, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөөний дагуу “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр ашиг, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангуудыг баталгаажуулсугай.

Хоёр. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга М.Батжаргалд зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайланг ҮАГ-ын Аудитын гуравдугаар газар, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга болон шалгагдагч байгууллагуудад хүргүүлж, аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын хоёрдугаар нэгжийн ахлах аудитор /Х.Алтанчимэг/-г даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА



003010010





Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2022 оны 1-дугаар Тушаалын Хавсралт № 1

Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

№	Аудитын чиглэл/асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (Мянган төгрөг)	Гаргасан шийдвэр
A	1	3	4	
1	Улсын төсвийн оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу, Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна уу	Архангай аймагт 2021 онд шингэр хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн болон эрх шилжээгүй нийт 30 төсөл, арга хэмжээний саналыг аргаачлалд заасан шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэх, үнэлэх, төсөвлөлтийн шаардлагыг хангуулж үнэлгээ өгсөн, эрэмбэлсэн талаар баримт материал цаасаар архивлаагүй нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй дагхан гаргасан нь МУЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.1.1.3-д "төслийг үнэлж, эрэмбэлэн төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулах", 2.1.2.1-д "төслийн саналыг аргаачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлж, үнэлэх" гэж заасныг хэрэгжүүлээгүй.		Албан шаардлага №319/A0340210
2	Улсын төсвийн оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу, Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн байдалд аймгийн Засаг даргаас дотоод хяналт шалгалтыг хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.2.8-д "... хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хяналт хийх ..." 14.2.9-д "... хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжиж дууссаны дараа хөрөнгө оруулалтын үр дүнд үнэлэх ..." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг дагхан гаргасан байна.		Албан шаардлага №319/A0340210
3	Улсын төсвийн оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна уу	Захиалагчтай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болсон нэр бүхий 8-н гүйцэтгэгчтэй гэрээг дүгнэж харууллаа тооцоох арга хэмжээ аваагүй байгаа нь ТБОНХБХА УХАГХ-ийн 46 дугаар 46.1.6 "Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавих...", МУЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилга захиалагчийн дүрэм"-ийн 3.6-д "Захиалагч ... гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, ... гэрээний дагуу хүргэсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана", гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний ерөнхий нөхцөлийн 46.1-д "Гүйцэтгэгч ажил дуусгавар төлөвлөсөн өдрөөс хугацаа холорсон хоног тугам гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө" гэж заасныг зөрчсөн.		Албан шаардлага №320/A0370216
4	Улсын төсвийн оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна уу	Тариат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 50 ортой өргөтгөлийн барилга, Хайрхан сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын өргөтгөлийн ажилууд болит гүйцэтгээс зөрүүтэй 669.2 сая төгрөгийн санхүүжилтийг тооцож олгосон нь МУЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.1.1.7-д "хууль, журмын шаардлага хангаагүй төслийн санхүүжилтийг олгохгүй байх" гэсэн заалсныг хэрэгжүүлээгүй.		Албан шаардлага №320/A0370216
5	Улсын төсвийн оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу, Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу	Аудитын явцад 2021 ашиглалтанд орсон 7 ТАХ нь ажлын гүйцэтгэл дутуу, ашиглалтын явцад эвдрэл гэмтэл гарсан байгаа нь Барилгын тухай хуулийн 14.6, 14.7 дахь хэсэг, МУЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.9-д "... барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засваруулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна ..." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.	669.2	Албан шаардлага №320/A0370216